

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН 7 ХОНОГИЙН ТАЙЛАН
/2022.10.31 - 2022.11.04/

2022.10.07

Дархан-Уул аймаг

№	Ажлын чиглэл	Үйл ажиллагааны гүйцэтгэл
Барилга хот байгуулалтын хэлтэс		
1	Барилга угсралтын чиглэлээр	<ul style="list-style-type: none"> ✓ Баянгол дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхээс ирүүлсэн О.Соёлмаагийн нэхэмжилтэй, “Ластинтернейшнл” ХХК, иргэн Д.Долгормаа нарт холбогдох иргэний хэрэгт хянан шийдвэрлэх ажиллагаанд шаардлагатай Дархан-Уул аймагт шинээр баригдаж байгаа орон сууцны үнийн судалгааг 2022 оны 8-р сарын байдлаар хүргүүлсэн. ✓ Барилгын тухай хууль өөрчлөгдөж байгаатай холбогдуулан саналыг боловсруулан газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт албан бичгээр хүргүүлсэн. ✓ Мэргэжлийн хяналтын газарт Дархан-Уул аймагт зөрчилтэй байгаа 20 барилга байгууламжийн судалгааг гаргаж арга хэмжээг авах тухай албан бичгийг хүргүүлсэн.
1	Инженерийн дэд бүтцийн чиглэлээр	<ul style="list-style-type: none"> ✓ Аймгийн хэмжээнд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн халуун усны барилга, ахуй үйлчилгээний барилгын судалгааг БХТ-д хүргүүлсэн. ✓ Дархан сумын 10-р багт баригдсан иргэн Д.Баярсайханы барилгын 1,2 тоотод оршин суугчдаас ирсэн гомдолын дагуу үзлэг хийж иргэн Д.Баярсайханд гомдол барагдуулах талаар хугацаатай албан тоот хүргүүлсэн. ✓ Аймгийн Захиарагчийн ажлын албанд нийтийн эзэмшлийн газар, барилга, байгууламж дээр зар сурталчилгаа байрлуулах зөвшөөрөл олгох журамд санал хүргүүлсэн. ✓ Шинээр татахаар төлөвлөж буй Дархан Сэлэнгэ чиглэлийн авто замын трассыг хянасан.
	Барилгын материал үйлдвэрлэл	<ul style="list-style-type: none"> ✓ 2022.11.04 Цахим сургалт-Эрчим хүчний хэмнэлттэй, дасан зохицох чадвартай орон сууцны стратегийг хөгжүүлэх ажлын хүрээнд зохион байгуулагдаж буй Suitability tool (Тохиромжтой байршил тодорхойлох) болон Urban Performance tool (Хотын үзүүлэлт) аргачлалын Сургалт-3 зохион байгуулагдсан.
Газрын удирдлагын хэлтэс		
1	Суурь судалгаа, газрын мониторинг	<ul style="list-style-type: none"> ➢ Дархан-уул аймгийн хэмжээнд захиалгат хянан баталгааны 10 тайлан баталгаажуулж, 13 тайлан хянаж зөвлөмжийн хамт буцаасан.
Захиргаа аж ахуйн чиглэл		
1	Мэдээллийн технологи, нярав	<p>Мэдээлэл: 70376471 нээлттэй утсаар 6, байгууллагын Facebook хуудсанд ирсэн 3 иргэн, ААНБ-ын асуултанд хариулт өгөв.</p> <p>Мэдээллийн технологи: Байгууллагын цахим хуудасны Нүүр хуудасны Тогтмол мэдээ хэсэгт “Цахим Дархан” төслийн хүрээнд хийгдсэн E-Darkhan, Ersdel Darkhan аппликейшны постер зургаар линк үүсгэн тус бүрийн товч мэдээлэл, постер зураг, татаж авах линкүүдийг оруулав.</p> <p>Байгууллагын Фэйсбүүк хуудсанд “Цахим Дархан” төслийн хүрээнд хийгдсэн E-Darkhan, Ersdel Darkhan аппликейшнуудын талаарх мэдээлэл, Залуус 1, 2 хорооллын зураг төсөл хийгдэж байгаа тухай мэдээлэл оруулав. Байгууллагын 12 албан хаагчийн гар утсан дээр E-Darkhan, Ersdel Darkhan аппликейшнуудыг суулгаж, аппликейшны ач холбогдол, хэрхэн ашиглах талаар заавар зөвлөгөө өгч ажиллав.</p> <p>Нярав: Газрын удирдлагын хэлтсийн мэргэжилтнүүдэд 3 ширхэг нэгж талбарын хувийн хэргийн хавтас олгож, кадастрын мэдээллийн санд өөрчлөлт оруулсны төлбөрийн баримт 9 ширхэгийг хүлээж авч бүртгэв.</p> <p>Шаардах хуудсаар 5 төрлийн 12 ширхэг бараа материал олгов. Хонгор сумын газрын даамлаас 2022 оны 1-9-р Нэгж талбарын хувийн хэргийн зарцуулалтын тайлан, 2021 оны 11, 12-р сарын, 2022 оны 1-9-р сарын кадастрын өөрчлөлтийн төлбөрийн баримтын тайланг шалгаж, хүлээн авав.</p>

Тайлан боловсруулсан:

Г.Нямдорж

Хянасан:

Газрын удирдлагын хэлтсийн дарга

Г.Нямдорж